



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/НЧН

Арвайхээр

### Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 76 дугаар зөвлөмжийн дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Арвайхээр, Хархорин суманд хийгдэх 1040 метр хайсан хашааны ажлыг 67793700 (жаран долоон сая долоон зуун ерэн гурван мянга долоон зуу) төгрөгөөр Болор өрөг ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100750